



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/39

Мандалговь

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.8, 16.1.10, 16.1.12, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тогтоолоор батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.3, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 3 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Д.Нацагдоржийн нэрэмжит шагналт яруу найрагч Пэрэнлэйн Нямлхагва нь “Машид тунгалаг” яруу найргийн тоглолтоо зохион байгуулж, олон жилийн хөдөлмөр бүтээлээ нийтийн хүртээл болгон сурталчилж байгаатай холбогдуулан аймгийн “Хүндэт өргөмжлөл” хадгалуулж, санхүүгийн дэмжлэг үзүүлсүгэй.

Хоёр. Тоглолт зохион байгуулах үйл ажиллагаанд нь 500000 /Таван зуун мянга/, хүндэт өргөмжлөл хэвлүүлэхэд 35000 /Гучин таван мянга/, нийт 535000 /Таван зуун гучин таван мянга/ төгрөгийг Засаг даргын нөөц сангаас гарган зарцуулахыг аймгийн ЗДТГ-ын дарга /О.Чулуунбат/, нягтлан бодогч /Ц.Даваа/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  О.БАТ-ЭРДЭНЭ



320000076